



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/812

Булган сум

“Чанарыг эрхэмлэгч шагнал олгох журам”-ыг
дүгнэх, үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2022 оны А/262 дугаар захирамжаар батлагдсан “Чанарыг эрхэмлэгч шагнал олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрэглэгчдийг чанартай, аюулгүй, баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах, орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоход идэвх санаачилгатай ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хөхүүлэн дэмжих, олон нийтэд сурталчлан таниулах, чанарын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилго бүхий аймгийн Засаг даргын нэрэмжит “Чанарыг эрхэмлэгч шагнал олгох журам”-ыг дүгнэж, үйл ажиллагааг зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Гантулга), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан) нарт үүрэг болгосугай.

2.Болзлын шалгуур үзүүлэлтийн шаардлага хангасан үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчийн нэрийг хавсралтаар баталсугай.

3.“Чанарыг эрхэмлэгч” шагналын зардал 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Аймгийн засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
12-дугаар сарын 25-ны/ний өдрийн
А/812-дугаар захирамжийн хавсралт



ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭГЧ” БОЛЗОЛД ШАЛГАРСАН
АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР

д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	2	3	4
1	Хутаг-Өндөр сум	“Булган мах маркет” ХХК	Экспортод чиглэсэн мал мах бэлтгэл, мах боловсруулах үйлдвэр
2	Рашаант	“Сод хан трейвл” ХХК	Улсын чанартай авто зам дагуух үйлчилгээний төв
	Нийт-2		

--o00o--